

ТҮҮХЧИЙН ИНДЭР

АСУУЛТ, ХАРИУЛТ

Олон ургальч үзэл өргөн дэлгэр болсон өнөө үед аливаа түүхэн үйл явдалд нягт нямбай, буурь суурьтай хандаж, олон талаас нь судлах шаардлага хэзээ хэзээнээс чухал болоод байна. Энэхүү шаардлагыг бид хичээнгүйлэн дагаж, тэртээ дал гаруй жилийн өмнө улс Монголд оч мэт гялалзан эхэлж байсан түүхэн гүн гүнзгий үйл явдлын талаар улс төрийн намуудаас баримталж буй үзэл баримтлал, мөн түүхчдийн санал бодлыг уншигч та бүхэндээ толилуулахаар доорхи гурван асуултыг ирүүлсэн хариултынх нь хамт нийтэлж байна. **Нэгдүгээр асуулт:** Сүүлийн үед 1921 оны Ардын хувьсгалын шинж чанарыг «үндэсний ардчилсан хувьсгал» хэмээн тодорхойлох боллоо. Энэ талаархи санал бодлоо дурдана уу? **Хоёрдугаар асуулт:** 1921 оны хувьсгалын дотоод, гадаад хүчин зүйл, түүний дотор Зөвлөлт Орос улсаас үзүүлсэн цэргийн тусламжийг хэрхэн үзэж байна вэ? **Гуравдугаар асуулт:** Энэхүү хувьсгалын Монголын түүхэнд эзлэх байр суурь, түүний ач холбогдлыг хэрхэн үнэлж байна вэ?

1. МоАН-ын дарга Э.Бат-Үүлийн хариулт

1. XX зууны эхэн үе буюу 1900 оны эхээр манжийн дарлалыг эсэргүүцсэн монголын ард түмний тэмцэл идэвхжиж, эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө улс үндэстнийг бүхэлд нь хамарсан хөдөлгөөний шинж чанартай болон эхэлсэн билээ. Энэ хөдөлгөөнд монголын эгэл жирийн ардууд өөрсдийн санаа зоригоор идэвхийлэн манлайлан оролцохын хамт тэр үеийн жижиг дунд ноёд түшмэд зарим феодалууд нэгдэн манж, хятадын ноёрхохын эсрэг, гадаадын худалдаачид, мөнгө улхүүлэгчдийн эсрэг үндэснийхээ эрх чөлөөний төлөө тэмцэн босож, улмаар 1911—1912 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн хэдийгээр бүрэн ялалтанд хүрч чадаагүй ч монгол улсын тусгаар тогтнолын замыг нээж, автономит Монгол улсыг дэлхий дахинаа зарласан юм.

Гэвч монгол орон харийн орны хараат хэвээр үлдэж, улмаар хятадын цэргийн эрхшээлд орж гадаадын худалдаачид, мөнгө хүүлэгчдийн нөлөө ихсэж ард түмнийг дарлан мөлжих явдал гарч байлаа. Энэ үед 1912 онд мандсан үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн маань ард түмний өргөн олон давхаргыг хамарч зохион байгуулалтанд орж улмаар ардын хувьсгалыг хийх тохироо нөхцөлийг бүрдүүлж байсан юм.

Энэ нь яваандаа монголын ард түмний эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөн болж тэр үеийн тэргүүний үзэл бодолтой сэхээтнүүд, зарим ноёд түшмэд, жижиг дунд феодалууд хамрагдан орж идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд Богд хаант засгийн газар ч зохих хэмжээний дэмжлэг үзүүлж байлаа. Энэ байдлаас үзэхэд 1921 оны ардын хувьсгал нь 1911—1912 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний шууд үргэлжлэл, үндэсний ардчилсан хувьсгалын шинжтэй хувьсгал байсан юм гэж МоАН үзэж байна. Хувьсгалт хөдөлгөөнд оролцогчид нь нийгмийнхээ бүрэлдэхүүнээр адилгүй янз бүрийн үзэл санаатай хүмүүс байсан боловч эх орноо харийн дайснаас чөлөөлөн, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн мандуулж, ард түмнээ дарлал зовлонгоос чөлөөлөх гэсэн нэгэн ерөнхий зорилгод нэгдэж байлаа.

2. 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дотоод хүчин зүйл нь гадаадын харгис цэргийн дарлал, шунахай худалдаачид, мөнгө хүүлэгчдийн харгис дээрэнгүй үйл ажиллагааг эсэргүүцсэн хувийн жижиг өмчит монголын малчин ардууд, зарим ноёдууд, жижиг дунд феодалууд байсан юм. Нийт ард түмний хувьсгалт үзэл санаа бүрэл-

дэн тогтож хувьсгал хийх тохироо дотоод хүчин зүйл бүрэлдэж байсан юм.

Гадаад хүчин зүйлийн хувьд ХХ зууны эхэн үе бүхэлдээ дэлхий дахины хувьсгалт хөдөлгөөний үр нөлөө түгэн дэлгэрч байсан цаг бөгөөд түүний дотроос 1911 оны Хятадын ардчилсан хувьсгал мөн манай хойт хөрш Орос оронд ялсан Октябрийн хувьсгалын нөлөө Монголд шууд тусч байсныг тэмдэглэх хэрэгтэй. Манай хувьсгалт хөдөлгөөн ч үүнийг ухаалгаар олж харж, мөн Зөвлөлт Орос улсаас цэргийн тусламж авч хэрэглэсэн нь хувьсгалыг гагцхүү ялалтанд хүргэхэд л зохих ач холбогдлоо өгсөн билээ.

3. 1921 онд ялсан хувьсгал нь 1924 оныг хүртэл Үндэсний ардчилсан хувьсгалын шинж чанараа хадгалж байсан бөгөөд монголын нийгэм улс төр, эдийн засгийн амьдралд үндсэн эргэлт хийсэн юм. Энэ хувьсгалын үр дүнд Монгол улс тусгаар тогтносон БНУлс болсон юм. Монгол улсын түүхэнд хөгжлийн цоо шинэ үе эхэлсэн бөгөөд монголын түүхийг цоо шинээр бичиж эхэлсэн юм.

II. МҮДН-ЫН ХТЗ-ИЙН ДАРГА Ж. БОРЫН ХАРИУЛТ

1. Манай оронд өрнөсөн түүхэн гүн гүнзгий үйл явц нийгмийн амьдралын өнцөг булан бүрийг, түүний дундаас хамгийн түрүүнд эрч хүчтэй өөрчлөгддөг нийгмийн сэтгэлгээг эзэмдэн авсан. Нийгмийн сэтгэлгээнд гарсан өөрчлөлт нийгмийн шинжлэх ухаан, тэр дундаа түүхийн ухааныг хөндөж түүхэн үйл явдлын бодит байдалд тохироогүй зарим нэр томъёог эргэж хянах зайлшгүй шаардлага гарч байна.

Монгол оронд урьд нь болж өнгөрсөн түүхэн үйл явдлууд үнэн бодит дүр төрхөө алдчих шахсан нь түүхэн агуу их гавьяа гэгчийн хойноос хэт хөөцөлдөж, ард түмнийхээ түүхээс туурга тусгаар өндөр түүхийг бий болгох гэж оролдсоны гай гамшиг юм. Бидний үзэж байгаагаар хэрвээ 1921 оны үйл явдалд бодитой хандах юм бол «ардын хувьсгал» ч биш, «үндэсний ардчилсан хувьсгал» ч биш харин үндэсхүний эрх чөлөөний хөдөлгөөний ялалт байсан юм. Үүний гол нотолгоо нь тэр түүхэн үйл явдлыг удирдан зохион байгуулсан хүмүүс, тэдэнд нэгэн мөрний хүч өгсөн ардуудын хүсэл эрмэлзэл нь үндэснийхээ эрх чөлөө, тусгаар тогтнолыг сэргээн өөрийн орныг улс шиг улс болгох гэсэн монголчуудын уламжлалт сэтгэлгээ л байлаа шүү дээ. Өөрөөр хэлбэл тэдний цор ганц хүсэл бол эх орноо улсын дайтай улс болгох зорилго байснаас биш элдвийн харь үзэл санаагаар урт удаан хугацааны хүчирхийлэл явуулах гээгүй нь мэдээж. Харин өөрсдийгөө «хувьсгалчид» хэмээн гадаад үг орчуулж нэрлэгчдийн хар гайгаар монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний жам ёсны өрнөл гажсан нь гачлантай. Ингэж монголын эх орончдын нөр их тэмцлийн үр дүн сулрахад хүрсэнийг харамсавч баршгүй.

2. 1921 оны үйл явдлын дотоод хүчин зүйл төгс бүрдсэн байсан. Өөрөөр хэлбэл харийн элдэв дарлал мөлжлөг, тэдний гар хөл болсон зарим нэгэн ухвар мөчид феодалуудын дарлалыг ханатал цадтал амссан монголчуудын улс үндсээ авран хамгаалах сэтгэл халин бялхалзаж байлаа. Түүний хажуугаар хоёр талаас шахан хавчиж байсан хоёр гүрний нэгийг нь төр халалцаж байсан нь дээрх хүсэл эрмэлзлийг хэрэгжүүлэх явдлыг боломжтой болгосон юм. Тиймээс ч үндэснийхээ эрх чөлөөний хөдөлгөөнийг аль болох бага хохиролтойгоор ялалтад хүргэх зорилгоор Зөвлөлт Орос улсаас цэргийн тусламж авсан явдлыг буруутгах аргагүй. Харин цаашдаа энэ сувгаар дамжин «цуст улаан хувьсгал экспортлогдон» орж ирснийг харамсавч барахгүй. Энэ гашуун сургамж биднийг зөвхөн холч ухаантай төдийгүй олон

дахин урлагтай, уян хатан байхыг одоо ч гэсэн уриалсаар байгаа юм.

3. Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөл жам ёсоороо замнаж байсан үе буюу 1925 он хүртэл нааштайгаар үнэлэх ёстой. Харин үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлтөөс улиран гарах улс төр, эдийн засаг, аж амьдралын үр дагаврыг мушгин гуйвуулж, хэт ургуулан зөгнөж мөрөөдөх замд оруулсан «хувьсгалчид» төр, засгийн нөлөө бүхий удирдах албан тушаалыг гартаа оруулж, намынхаа нэрэнд хүртэл «хувьсгалт» гэдэг гуншин нэмсэн үеэс эхлэн буруу замаар будаа тээсэн үе гэж дүгнэхээс өөр аргагүй. Тэр тусмаа хүнд ачаатай төөрчихлээр замаа олох гэж хичнээн их хүч хөдөлмөр гаргаж ядарч туйлддагийг монгол хүмүүс хэнээс ч илүү сайн ойлгоно. Замаа алдаж будилалгүй үндэснийхээ дэвшилтэд зүйл, соёл иргэншилдээ тулгуурлан хөгжиж чадсан бол өнөөгийн хөгжил гээд байгаа харагдахын төдий хэдэн зам гүүр, барилга, байгууламж, зан суртахууны өөрчлөлтөөс хамаагүй өндөр хөгжилд хүрэх байсан юм гэдгийг хүн болгон ойлгох нь чухал. Тэгж чадвал ийм гажуудал дахин гаргуулахгүй байхын баталгаа болох юм.

III. МСДН-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ж. Бямбасүрэнгийн хариулт

1. Бид уг хувьсгалыг албан ёсоор «Монголын үндэсний сэргэн мандалтын хувьсгалын хоёрдугаар үе шат эхлэв» (МСДН-ын Анхдугаар их хурлын улс төрийн илтгэл, 1990. III. 31 УБ хот) гэж дүгнэсэн юм. Үнэндээ энэ бол нэг ангийн дарангуйллыг нөгөөгөөр солих ч юм уу нийгмийн нэг байгууллыг нөгөөгөөр халахын төлөө тэмцэл биш байлаа. Харин түрэмгийлэгчдийг хөөн зайлуулж, Монгол улсынхаа тусгаар тогтнолыг сэргээн мандуулахын төлөө тухайн үеийн дэвшилт үзэлтэй харц ард, ноёд баяд ялгалгүй хамтран тэмцсэн юм. Тэгэхлээр энэ хувьсгалыг шинж чанарынх нь хувьд «үндэсний ардчилсан» хэмээн тодорхойлох нь зүйд илүү нийцнэ.

2. Энэ үйл явц өрнөж ялалтанд хүрсэн гол хүчин зүйл нь:

- Монгол орон харийн цэргийн хөлд талхлагдаж, үндэс угсаагаараа устгах аюул нүүрлэсэн энэ үед улс үндэснийхээ тусгаар тогтнол, эрх чөлөөг сэргээн тогтоох үзэл санаа дахин эрс идэвхжиж, эх оронч хүмүүс нэгдэн, тэмцлийн янз бүрийн арга замыг эрэлхийлж, зохион байгуулалтын хэлбэрт орж чадсан явдал юм. Харин үүнийг үзэл суртлын түүхчид Лениний хувьсгалын тохирооны тухай онол гэгчээр тайлбарлахыг оролдож ирснийг дашрамд дурдъя.

Мөн хувьсгалыг ялалтанд хүргэхэд гадаад хүчин зүйл, тухайлбал Зөвлөлт Орос улсын улаан цэрэг шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэсэн. Энэ «ялсан пролетарийн тусламж» шууд орж ирэх болсон гол шалтгаан нь:

- В. И. Ленин тэргүүтэй оросын хувьсгалчид большевик үзэл суртлаа Орос оронд төдийгүй ойр хөрш улсууд, цаашилбал дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэх асар их сонирхолтой байв. Иймд монголын «хувьсгалчид» тэднээс тусламж гуйсан явдал аятай боломж болсон.

-Октябрийн хувьсгалаас дайжиж, монголд бүгсэн цагаантны цэргийг даруй бутцохих явдал чухал байв. Учир нь Барон Унгерн өмнөд хөрш монголыг Зөвлөлт Орос улсын эсрэг дайны түшиц газар болгочихож магадгүй байсан. Ийнхүү цагаантныг даран сөнөөх тал дээр хоёр талын ашиг сонирхол нийцэж байв.

- Монголыг Хятадад бүрмөсөн алдчихгүйн төлөө Их Оросын уламжлалт үзэл мөн нөлөө үзүүлсэн.

3. 1921 оны хувьсгал Монгол улсын түүхэнд жинхэнэ эргэлтийн шинжтэй үйл явдал болсон. Энэ нь нэг талаас монголын ард түмэнд

туурга тусгаар төр улсаа шинээр мандуулах боломжийг олгосон бол нөгөө талаас монгол орны өвөрмөц нөхцөл байдал, монгол хүний язгуур зан суртахуунд харш коммунист үзэл суртлыг тулган хүлээлгэх эхлэлийг мөн тавьсан билээ.

IV. Академич Б. Ширэндэвийн хариулт

1. 1921 оны ардын хувьсгалын шинж чанарыг урьд тодорхойлж байсан томъёог шинэ сэтгэлгээний үүднээс эргэн харж үзэхийг эрмэлзсэнээс түүний шинж чанарыг үндэсний ардчилсан хувьсгал гэж манай нэлээд түүхчид үзэж буйгаас гадна, МАХН-ын мөрийн хөтөлбөрийн төсөлд ч энэ байдлаар тусгагдаад байна. 1921 оны хувьсгалын зорилт, гүйцэтгэсэн үүргийг нь авч үзвэл харийн түрэмгийлэгчдээс Монгол орныг чөлөөлж, улс орныхоо тусгаар тогтнолыг мандуулж, ард түмнийг колоничлол, феодалын дарлалаас чөлөөлөхөд чиглэсэн болохоор үндэсний ардчилсан хувьсгал гэж үзэх нь үндэстэй гэж би бодох боллоо. Иймэрхүү шинж чанартай хувьсгал XX зууны эхэн, дэлхийн I дайны явц ба дүнд харийн түрэмгийлэгчдийн дарлалд байгаад чөлөөлөгдсөн ард түмний хувьсгалууд хичнээн өвөрмөц талтай болсон боловч үндсэндээ уг чанараараа төстэй байсан хэмээн үзэх тал бий.

2. 1921 оны хувьсгал гарах болсон нь гадаад талаас, монголын ард түмний 1911 оны эрх чөлөөний хөдөлгөөний ололтыг хятадын эзэрхий гэмин цэрэг хүчээр түрэн устгаснаас гадна, мөн Оросын цагаан намын цэрэг тус оронд цөмрөн орж, харгис дэглэм тогтоосноор Богд хаант улсын төрийн тусгаар тогтносон байдал бүрмөсөн алдагдсантай холбоотой. Улс орны дотоодод Богд хаант улсын үед шинэчлэлт зарим талаар хийгдсэн боловч, хамжлага албат, шавь түмэн олон улс төрийн эрх чөлөөгүй, хар шар феодалын элдэв ноёрхлын зэрэгцээ гадаадын мөнгө хүүлэгчдэд мөлжигдөн сорогдож ард түмний аж байдал тэсэхүйеэ бэрх болсон билээ.

Монгол ардын намын удирдлагаар эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэн боссон ард түмэн, түүний журамт цэргийн хүчээр хятадын түрэмгий цэргийг Монголоос хөөн зайлуулсан ардын хувьсгалын анхны том амжилт байв. Оросын цагаан намын цэрэгтэй тэмцэн, тэдний гараас эх орноо чөлөөлөхөд Зөвлөлт Орос улсаас үзүүлсэн цэргийн тусламж онцгой чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Ийм тусламжгүйгээр манай ард түмэн үндэсний тусгаар тогтнолоо байлдан олоход бэрх байсан нь маргахын аргагүй.

3. 1921 оны үндэсний ардчилсан хувьсгал ялан дийлснээр Монголын түүхэнд цоо шинэ хуудас нээгдсэн юм. Энэ нь Монгол улс тусгаар тогтнолоо байлдан олж, батжин бэхжүүлэх ба цаашдаа олон улсаар хүлээн зөвшөөрөгдөж, дэлхийн улс орнуудын хамтлагийн гэр бүлд тэгш эрхтэй гишүүн болж, улс орнуудтай тэгш эрх, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн билээ. Хувьсгалын үр дүнд Монгол оронд олон зуун жилээр ноёрхож ирсэн феодалын нийгэм ардын ардчилсан шинэ нийгмээр солигдож, ардын төр засгийн тогтолцоо бүрэлдэж, ард олон хамжлагат ёсны харилцаанаас ангижран, шинэ ахуй амьдрал соёлоо хөгжүүлэх бололцоотой болсон юм. Энэ түүхэн замд гадаад дотоодын шалтгаанаас болж алдаа завхрал ихээхэн гарч байсан. Эдгээрийг эдүгээ эрс залруулан засч, улс орондоо ардчилал, ил тод байдлыг хэрэгжүүлж, ардчилсан хүмүүнлэг нийгмийг хөгжүүлэхээр чиглүүлж буй нь ардын хувьсгалын 70 жилийн дотор олсон амжилтыг цаашид гүнзгийрүүлэн явуулж байгаа манай нийгэмлэгийн эдүгээ ба ирээдүйн хувьд түүхт ач холбогдолтой үйл явдал болж байна.

V. Түүхийн ухааны дэд эрдэмтэн С. Ичинноровын хариулт

1. 1921 оны Монголын ардын хувьсгал, түүний шинж чанар нь уг хувьсгалын тавьсан зорилт, хөдлөх хүч, шийдвэрлэсэн асуудалтай холбоотой юм. Энэ асуудлыг манай түүхийн удирдамжийн шинжтэй баримт бичгүүд, судлаачдын бүтээлд янз бүрээр тодорхойлж ирэхдээ түүний үндэсний давамгайлах шинжийг хадгалсаар байсныг тэмдэглэх хэрэгтэй. 1960-аад онд хэвлэгдсэн МАХН-ын товч түүхэнд 1921 оны Монголын ардын хувьсгал нь: «өөрийн зорилго, шинж чанараараа империализм, феодализмыг эсэргүүцсэн шинэ маягийн ардчилсан хувьсгал байв» гэж энэ хувьсгалын үндэсний ба нийгмийн шинжийг тодорхойлсон юм. Энэ тодорхойлолтыг үндсэндээ баримталж ирлээ. 1921 оны ардын хувьсгалын хурц үзүүр нь харийн түрэмгийлэгчдийн эсрэг чиглэж байсан нь тодорхой. Энэ тэмцэлд үндэсний эх оронч бүх хүчийг нэгтгэх зорилт тавьж хэрэгжүүлсэн нь ч үнэн. Энэ бүхнээс үзсэн ч улс үндсээ чөлөөлөх хандлага давамгайлж байсан нь эргэлзээгүй. Тэгэхдээ угсаа залгамжлах феодалын төрт ёсыг хувьсгалаар халж, сонгуулийн ардчилсан төр ёс тогтоох эрмэлзлэл тууштай байсныг үгүйсгэх аргагүй билээ. Иймээс харийн түрэмгийлэн эзлэгчдээс улс үндсээ чөлөөлөх феодалын дарлалыг устгаж ардчилсан хувьсгал хийх нь 1921 оны ардын хувьсгалын гол зорилт байжээ.

2. 1921 оны ардын хувьсгалын дотоод, гадаад хүчин зүйлийн тухайд бол уг хувьсгал нь тухайн нийгмийн байгууллын гүнзгий хямралтай холбоотойгоор ихэнх аймаг, хошууд, нийт үндэстнийг хамран өрнөсөн, нөгөө талаар хувьсгалын хөдлөх гол хүч нь малчин ардууд байсныг манай түүх судлал нэгэнт тогтоожээ.

Гадаад хүчин зүйл, Зөвлөлт Орос улсын цэргийн тусламжийн тухайд, аливаа хувьсгал өөрийн гадаад түшиг, дэмжигчтэй байдаг. Монголын хувьсгалын тийм түшиг нь Октябрийн хувьсгалын өлгий Зөвлөлт Орос улс байсан. ЗОУ-ыг түшиглэх гэсэн эрмэлзлэл нь зөвхөн 1921 оны хувьсгалтай холбоотой гарч ирсэн зүйл биш, бүр 1911 оны монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, түүнээс өмнө ч байсан уламжлалтай юм.

1921 оны хувьсгалд ЗОУ-аас үзүүлсэн цэрэг, зэвсгийн тусламж нь монголын хувьсгалчдын төлөөлөгчдөөс ард түмнээ төлөөлөн тавьсан хүсэлтийг нааштай хүлээн авч тусламжийн гараа сунгасан хэрэг гэж үзэж байна.

3. 1921 оны Монголын ардын хувьсгал нь 1911 оны монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний шууд үргэлжлэл монгол оронд ялан мандсан нийгмийн хувьсгал байсан нь маргаангүй билээ. Монголын ард түмэн бол эртний уламжлалтай, тэмцлийн өвөрмөц арга барилтай тэмцэгч ард түмэн билээ. Тэмцлийн арга барил нь ч хөгжин боловсорч байсан юм. Зарга тэмцлийн болон дугуйлангийн хэлбэрээс улс төрийн удирдлага бүхий нууц байдалд шилжсэний үр дүн нь 1921 оны ардын хувьсгал билээ. Энэ хувьсгал улс үндсээ харийн дарлалаас чөлөөлөөд зогсоогүй уламжлалт феодалын байгууллыг нийгмийн хувьсгалаар халж «дарлах, дарлагдахын зовлонгүй аж төрөх» ардын ардчилсан төр ёсны тогтолцоо бүхий шинэ нийгмийн байгуулалд шилжин орох өөрчлөн байгуулалтын эхийг тавьснаараа Монгол орны түүхэнд урьд өмнө байгаагүй нийгмийн хувьсгал болсонд түүний түүхэн ач холбогдол оршино.

VI. Түүхийн ухааны дэд эрдэмтэн М. Ринчингийн хариулт

1. Ардын хувьсгалын шинж чанарын асуудлыг цаашид өргөжүүлэн гүнзгийрүүлж бодит үнэн байдалд нь улам ойр төсөр болгох чиг-

лэлээр лавшруулан судлах нь манай нэн шинэ түүхийн бүх асуудал, нийтлэг ба үндэсний онцлогийг нягтлан тодруулахад зарчмын чухал ач холбогдолтой юм.

1988 оны 1-р сарын 30-нд Түүхийн хүрээлэнд «БНМАУ-ын нэн шинэ түүхийн зарим онцлог асуудлууд» сэдвээр хийсэн онол, арга зүйн ярилцлагад, Ардын хувьсгалын шинж чанар агуулгын асуудлыг дахин хөндөж, Монгол ардын хувьсгал бол үндэсний хувьсгалын шинжтэйгээр үүсч ялан мандсан бөгөөд энэ нь ч тодорхой баримттай юм. Монгол ардын хувьсгал нь үндэсний хувьсгал байсан бөгөөд энэ шинж чанараараа хөрөнгөтний ардчилсан хувьсгалын хэв маягт хамаарна. Тэгээд ч нэгэн үе ардын хувьсгалыг-үндэсний хувьсгал гэж нэрлэж байснаа 1932 оноос Коминтернээс Монголын хувьсгалын талаар өгсөн тодорхойлолтыг баримтлан шинэ маягийн хөрөнгөтний ардчилсан хувьсгал гэж нэрлэх болсон билээ.

Монгол ардын хувьсгал бол үндэсний хувьсгалын шинжтэйгээр үүсч ялалтанд хүрсэн бөгөөд улмаар өрнөн хөгжиж 1924 оны үеэс ардын ардчилсан хувьсгал болж дараагийн шатнаа дэвшин орсон билээ.

1921 оны Монгол ардын хувьсгал, ардын ардчилсан хувьсгалын шинжтэй юм уу, эсвэл үндэсний хувьсгалын шинжтэйгээр үүсч ялалтанд хүрээд, улмаар ардын ардчилсан хувьсгалд урган орсон юм уу гэдгийг зааглан авч үзэхдээ, монголын хувьсгалчдын дэвшүүлсэн гол уриа, гол зорилтыг эрхиш харгалзан үзэх нь чухал юм. «Намын хүмүүсийн дагаж явах тангарагийн бичиг»-ээс эхлээд, манай намын анхны баримт бичгүүд, «Монголын үнэн» сонины өгүүлүүд, намын анхдугаар программ «Монгол ардын намаас гадаад монголын түмэнд тунхаглан зарлах бичиг» зэрэгт: «алдагдсан эрхээ эргүүлэн авах», «төр шашныг бататгах», дотоод засгийг засамжлах», «ядуу дорд ард түмний тусыг туйлаар бодох», «монгол үндэстэн өөртөө эзэрхэн улс байгуулах гэх мэт гол зорилтоо тодорхойлж байжээ.

Монгол орон хятадын милитаристуудын эрхшээлд автагдаж тусгаар байдлаа алдсан, Унгерны цагаантан довтлон ирж, улс төрийн хямрал улам хурцадсан, булаан эзлэгчдийн дарангуйлал гаарсан тийм нөхцөлд нийт монголчуудыг харийн түрэмгийллийн эсрэг тэмцэлд уриалан босгож, хүчийг нь нэгтгэх явдал тулгамдсан зорилт байх уу, эсвэл феодалын эсрэг тэмцэж улс төрийн хямралыг үндэсний хямралын шинжтэй болгох явдал илүү чухалчлагдаж байсан уу гэдгийг сайтар эргэцүүлэн тунгаах нь чухал юм.

1921—1924 онд тус орны улс төрийн амьдралд нэг бус удаа зөрчил, тэмцэл гарч, монгол орны хөгжлийн хэтийн төлөвийн асуудлаар зөрөлдөөн үүссэн нь үндэсний хувьсгалаас урсгалаараа хөрөнгөтний ардчилалд уу, эсвэл «ухамсартай үйл ажиллагаагаар» ардын ардчиллын замд шилжих үү гэдэг асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой байв.

МАХН-ын Ш их хурал, дээрх асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэнээр үндэсний хувьсгалаас ардын ардчилсан хувьсгалд шилжих шилжилт эхэлжээ.

2. Монголын үндэсний хувьсгалын тохироо бүрэлдэхэд гадаад хүчин зүйлийн нөлөө онцгой ач холбогдолтой байв. Энэ нь 1911 оны үндэсний эрх чөлөөний төлөө тэмцлийн ололт амжилтыг хөрш хаант Орос, Дундад Иргэн улс хамтын хүчээр нухчин дарж Монголд автономит байдлыг тулган хүлээлгэсэн 1915 оны Хиагтын гурван улсын хэлэлцээр болон Октябрийн хувьсгалын ялалтын үрээр 3 улсын хэлэлцээр «эзэнгүйдэж», энэ хэлэлцээр нь зөвхөн Монгол, Хятадын хэлэлцээрийн шинжтэй болсон явдалтай холбогдоно. Гурван улсын хэлэлцээрийг батламжлан сахигч нэг гол хүч хаант засаг унаснаар Мон-

гол улс, Дундад Иргэн улсын хавсарган нэгтгэх бодлогын өмнө ямар ч хамгаалалтгүй үлдсэн юм. Тэгээд ч Дундад Иргэн улс цэрэг хүчээ Монголд түлхэн оруулж «гадаад монголын автономийг» устгаснаар монголын нийгмийн сэтгэл зүйд үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө үзэл санаа дахин эрч хүчтэйгээр өрнөж, хувьсгалт бодит үйл явдалд хүрсэн юм.

Монголд цөмрөн орж ирсэн Унгерны цагаантны эсрэг тэмцэлд Зөвлөлт Орос улсаас үзүүлсэн цэргийн тусламж, үндэсний хувьсгалын өрнөлт, ялалтын үйл хэрэгт шийдвэрлэх ач холбогдолтой байв. Хэрвээ Монголд Унгерны цагаантан орж ирээгүй байсан бол монголын үндэсний хувьсгалын өрнөлт, ялалт нь туйлын хүнд хүчир байдалтай болох байсан болов уу даа,

3. Монгол орны хөгжлийн хандлага, чиглэлд эрс өөрчлөлт хийсэн онцгой ач холбогдолтой үйл явдал юм. Үүгээрээ эх орны түүхэнд онцгой байр эзэлдэг билээ.

VII. Түүхийн ухааны дэд эрдэмтэн Т. Лхагваагийн хариулт

1. Би бол дээрх үзэл санааг баримтлагчдын нэгэн. Хувьсгалын зорилго, шийдвэрлэсэн асуудал, хөдөлгөгч хүчний шинж байдлыг үзвээс монгол ардын хувьсгалын шинж чанарыг өөрөөр үнэлэхэд үнэндээ бэрх юм. Тэр цагт нийгмийн болон үндэсний шинжтэй олон зорилт, эрх ашиг давхцаж гарч ирсэн бөгөөд эдгээр нь улс үндэс, шашны суртлаа сэргээж мандуулах, тусгаар тогтнолоо олж бататган бэхжүүлэх, ардын эрхийг эрхэмлэх явдалд голлон зангидагдаж байлаа. Гэвч эн тэргүүнд дэвшигдэж, үүгээрээ ч лам нар, ард феодал зэрэг янз бүрийн анги, давхрааны хүмүүсийг нэгтгэсэн үзэл нь монголын хувьсгалчдын улс үндсээ гэх сэтгэл байсан юм. Тэр үеийн нийгмийн зөрчил ч асуудлыг ингэж тавихад хүргэсэн юм. Энэхүү үндэсний зорилтыг дараахь хоёр утгаар авч үзмээр байдаг. Энэ нь **нэгд**, улс үндэснийхээ тусгаар тогтнол, биеэ даасан байдлыг сэргээн бататгах, **хоёрт**, төр улсаа үндэсний зөвшлийн замаар төвхнүүлэн, хөгжүүлэх явдалд хамаарах учиртай. Харийн түрэмгийлэгчдээс эх орноо чөлөөлж, тусгаар тогтнолоо тунхаглан зарласнаар хувьсгалын үндэсний зорилт дуусчихаагүй юм. Харин ч хамгийн гол асуудал нь ардаа үлдсэн байна. Энэ нь хувьсган өөрчлөх чиглэл юм. Дээрх зорилтыг ардын засаг шийдвэрлэж эхлэхдээ аль нэгэн ангийн эрх ашгийг туйлаас огоорон туйлшралгүйгээр эе эвийг хичээх үндсэн дээр асуудалд хандсанд хувьсгалын үндэсний зорилт том томруун тусгагдаж, хүнлэг энэрэнгүйн шинж нь хэрэгжиж эхэлжээ хэмээн хэлж болно. Ардын хувьсгалын бүр эхнээс МАН, монголын хувьсгалчдын үзэл санааны амин сүнс байсан ардын эрхийг эрхэмлэх, дарлал мөлжлөгийг устгах бодол санаа үндэсний зорилтын хүрээнд уусаж алга болж үгүйсгэгдээгүй, харин ч үндэсний зорилтыг шийдэх ноён нуруу болж байлаа.

Монгол ардын хувьсгал нь үндэсний сэргэн мандалтын зорилгод харш. хуучны үзлийг бүрэн үгүйсэх, хөгжил дэвшил, ардчилал, шударга ёсыг эрхэмлэх үзэл санааг агуулж байснаараа ардчилсан агуулгатай бөгөөд аль нэгэн нийгмийг халах, солиход биш, ухаангүй засаглал, уруудсан уг үндсээ илүү дэвшилттэй соёл иргэншлээр халах эхлэл болсон. Тэр үеийн бодит зөрчил үүнд хүргэсэн учраас үндэсний болон нийгмийн шинжтэй түүхэн эргэлт гарсан ажээ. Иймээс ч энэ хувьсгалыг хөрөнгөтний болон социалист хувьсгалын хэв маяг хэмээх ойлголтод шууд хамааруулах боломжгүй, харин Ази, Дорнодахины улсуудын хувьсгалын хэв маягт илүү дөхөж очих, Монгол дүр төрхтэй хувьсгал гэвэл үнэнд ойртох болов уу. Үүний гол утга учир нь,

харийн түрэмгийлэгчдийн тухайд хатуу, эрс зоримог атлаа дотооддоо эе эвийг хичээсэн, үндэсний ба ангийн эрх ашиг, хуучин шинийн зөрчил, янз бүрийн үзэл санаа нэвт сүлжилдсэн, аль нэгэн туйлшрал багатай, хүнлэг тал нь давамгайлж байсанд оршино.

2. Монголын ард түмний үндэсний ухамсар сэргэж, хувьсгалт урам зориг төрөхөд гадаад нөлөө, түүний дотор Октябрийн хувьсгал нөлөөлсөн нь маргаангүй боловч дотоод хүчин зүйл шийдвэрлэх үүрэгтэй байсан. Эх орондоо хайртай монгол хүн л юм бол тэмцэхээс өөр аргагүй нөхцөл байдал тэр үед бий болсон байлаа. Харин харийн түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэлд Зөвлөлт Орос улсын цэргийн тусламж зайлшгүй шаардагдсан, өөр арга замыг түүх дэвшүүлж тавиагүй юм.

3. Ардын хувьсгал бол 1206 онд Монголын нэгдсэн төр улс тогтоосны дараа орох түүхэн үйл явдал, шинэ бөгөөд сайн цагийн эхлэл байлаа.

Жич: МАХН-аас асуултын хариуг ирүүлсэнгүй.